



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИНЭЧЛЭЛ:

Иргэний зөвлөл, Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл /ИЗ гэх/, олон нийтийн цагдаагийн ажилтан /ОНЦА гэх/-ы үйл ажиллагаанд үнэлэлт өгөх зорилгоор ТББ-уудад мониторингийн тэтгэлэг олгосон билээ. ННФ-ын тэтгэлгээр Үндсэн уртраг, Сэтгэлзүйн мэдрэмж, Тэгш тус төрийн бус байгууллагууд 6 сар гаруй хугацаанд мониторинг хийсэн бол Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Завхан, Сэлэнгэ, Орхон, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн 29 ТББ өөр өөрийн аймагт 1-2 сарын хугацаанд “бэсрэг” мониторинг хийж гүйцэтгэсэн юм.

Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хууль зүйн сайдын 2014 оны А/89, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 382, 383, 384 дүгээр тушаалаар батлагдсан дүрэм журмын хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх, гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор асуулга, баримт бичгийн шинжилгээ, экспертийн, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх арга зүйг ашиглан мониторинг явууллаа. Орон нутагт мониторинг хийсэн ТББ-ууд нь ННФ-аас 2015 онд зохион байгуулсан бүсчилсэн сургалтад хамрагдан мониторингийн арга зүйд суралцсан юм.

Мониторинг тус бүрийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn цахим хуудаснаас үзэх боломжтой.

МОНИТОРИНГИЙН ДҮН

ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Мониторингид хамрагдсан аймаг, нийслэлийн хүн ам Монгол Улсын нийт хүн амын 70 гаруй хувийг эзэлдэг ба ИЗ-д 6-18 хүн тус тус нэрээ дэвшүүлжээ. Тус бүс нутгийн хүн амын тоотой харьцуулбал энэ нь тун чамлалттай үзүүлэлт юм.
- Орхон аймаг хэнийг иргэний төлөөлөл гэж үзэх нь тодорхойгүй байсан тул ИЗ-ийн гишүүдийг Сонгон шалгаруулах комиссоо иргэний төлөөлөлгүй байгуулжээ.
- Сонгон шалгаруулах явц хэт удаан, хүндрэлтэй байна гэж мониторингид хамрагдсан нийслэл, аймгийн холбогдох албаны хүмүүс шүүмжилсэн /Одоогийн дүрмээр нийт 61 хоногийн хугацаа зарцуулахаар байна./.
- Цахим хуудсаар санал авах ажлыг хэрхэн зохион байгуулах нь тодорхойгүй байснаас хүндрэл учирсан байна. Тухайлбал, цахимаар санал авах явцад нэг аймагт нэг компьютерээс 2500 гаруй санал өгсөн тохиолдол гарчээ.
- ИЗ-д нэрээ дэвшүүлсэн хүмүүсийг шалгаруулах саналыг “цахим хуудсаар”, “сумын ИТХ, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал /ИНХ гэх/-аар



явуулна” хэмээн 2 хэлбэрээр тодорхойлсон. Иргэдээс санал авахдаа хоёуланг нь ашиглах уу, эсхүл аль нэгийг сонгох боломжтой юу гэдгийг дүрэмд тодорхой заагаагүй. Тиймээс зарим аймаг зөвхөн цахимаар санал авсан бол цөөн аймаг ИТХ, ИНХ-аас санал авч, үлдсэн нь аль аль хэлбэрийг ашиглажээ.

- ИЗ-ийн гишүүдийг Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1-р зүйлд нийцүүлэн ялгамжтай хугацаагаар томилох ёстой байтал зарим аймаг бүх гишүүдээ 3 жилийн хугацаатай томилжээ. Ялгамжтай хугацаагаар хэрхэн томилохыг журамлаагүй тул ижил хугацаагаар томилсон гэж шалтгаанаа тайлбарласан.
- ИЗ-ийн гишүүдийг ажил, мэргэжлээр нь авч үзвэл ихэвчлэн хуулийн болон хууль сахиулах байгууллагад ажиллаж байсан хүмүүс бөгөөд хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлж байна. Цагдаагийн байгууллагынхан ИЗ-д хууль сахиулах байгууллагын талаар мэддэг хүн байх нь шинэ тутам бүтцийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзсэн бол иргэд, иргэний нийгмийн байгууллагууд үүнийг ашиг сонирхлын зөрчил үүснэ хэмээн нилээд шүүмжлэлтэй хандсан.
- Иргэний зөвлөлийн үйл ажиллагааны зардал, гишүүдэд олгох урамшууллыг аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ хэмээн заасан ч төсөвт хэрхэн суулгах талаар нэгдсэн аргачлал байхгүй тул энэ нь 0 – 375000 төгрөг орчимд хэлбэлзэж байна. Аймгууд урамшууллыг олгохдоо ИТХ-ын төсвөөс, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /ГХУСАЗЗ гэх/-ийн зардлаас гэх мэт ялгамжтай байдлаар зохицуулжээ.
- Ихэнх аймагт ИЗ-д урамшууллаас өөр зардал өгөхгүй байгаа тул хуралдаан хийх төдийгөөр л үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байна. Нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага ИЗ-ийн талаар ойлголт мэдээлэл муу байгаа нь санхүүжилтэд мөн сөргөөр нөлөөлж байна.
- ИЗ нь цахим хуудастаа хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хөтөлбөр, холбогдох мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан, урамшуулал, хуралдаанд оролцсон ирцийн мэдээллийг дараа жилийн 1-р сарын 15-ны дотор байршуулна гэсэн заалт ч нэг мөр хэрэгжихгүй байна. ИЗ-д зориулсан тусдаа цахим хуудас байх уу, ИТХ-ын цахим хуудсанд байршуулах уу гэдгийг хууль, дүрэмд тодорхой заагаагүй. Албан ёсны цахим хуудастай ИЗ байхгүй бөгөөд зарим нь ИТХ-ын цахим хуудсанд өөрийн хуудсыг бий болгосон бол зарим нь фэйсбүүк хуудас нээх замаар энэ асуудлыг шийдэх оролдлого хийжээ. Гэвч эдгээр цахим хуудас нь зохион байгуулалт муутай тул хүссэн мэдээллээ олж авахад хэрэглэгчдэд хүндрэлтэй байна. Үүний зэрэгцээ алдаг оног мэдээлэл тавьжээ.
- Дүрмийн 5.1.3 /г/-д заасан “гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны талаарх иргэдийн санал, хүсэлт авах хайрцгийг цагдаагийн байгууллагад байрлуулж, дүн шинжилгээ хийх” гэсэн чиг үүрэг нь Цагдаагийн албаны тухай хуулийн 22.1.1-т заасан “цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцох”-ыг хориглох заалттай зөрчилдөж байж болзошгүй тул нягтлах шаардлагатай байна.
- Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгийн ИЗ нь Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, ИТХ-д албан бичгээр тодорхой санал хүргүүлж, зарим үр дүнд хүрчээ. Тухайлбал, Хөвсгөл аймгийн ИЗ нь ИЗ, ОНЦА-ны төсвийг яаралтай шийдүүлэх хүсэлтийг ХЗЯ-нд, Орхон аймгийн ИЗ нь цагдаагийн байгууллагад хандан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар, мөн цагдаагийн алба хаагчдын ээлжийн амралтын мөнгийг хугацаанд нь олгож байхыг зөвлөжээ. Дархан-Уул аймгийн Цагдаагийн хэлтэс ИЗ-өөс ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн “Хүүхдийн алба”-ыг “Хүүхэд, гэр бүл, хүчирхийлэлтэй тэмцэх тасаг” болгон өргөжүүлжээ.



ОЛОН НИЙТИЙН ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ ТОМИЛГОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ОНЦА ажилласнаар гэмт хэрэг, зөрчил буурахад бодитой үр дүн гарч байна гэж мониторингид хамрагдсан иргэд, албан тушаалтнууд үзэж, ОНЦА-ы тоог нэмэх санал гаргасан.
- ОНЦА-ы урамшуулал, таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгсэл, сургалт явуулахтай холбогдсон зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ хэмээн зохицуулсан. Гэтэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлд ОНЦА-ны урамшууллыг л олгохоор заажээ.
- Төсөв байхгүй гэсэн шалтгаанаар хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцсаар хангагдаагүй ОНЦА хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. ОНЦА-ыг сургаж, дадлагажуулахад зориулсан зардлыг нийслэл, зарим аймагт тусгайлан санхүүжүүлсэн бол ихэнх аймагт нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хариуцан явуулсан байна. Мөн түүнчлэн сумдаас аймгийн төвд очиж сургалтад суусан ОНЦА-д томилолт олгоогүй нь тухайн хүмүүст хүндрэл учруулжээ. Үүний зэрэгцээ Дархан-Уул аймаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг бүхэлд нь ОНЦА-ны урамшуулалд зарцуулснаас үүдэн хуулиар хүлээсэн бусад чиг үүргээ санхүүжүүлэх төсөвгүй болжээ.
- Нэг бүрийн, холбооны болон хамгаалах тусгай хэрэгслээр хангахаар зохицуулсан ч ОНЦА хэрхэн хэрэглэхийг журамлаагүй, төсөв байхгүй гэсэн шалтгаанаар мониторинг хийсэн нийт аймагт хангалт огт хийгдээгүй байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 24.7-р зүйлд “холбооны болон хамгаалах тусгай хэрэгсэл тавьж олгоно”, 24.9-р зүйлд “...нэг бүрийн тусгай хэрэгсэл,... зардлыг тухайн шатны Засаг дарга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлнэ.” хэмээн тус тус заасан. Гэсэн хэдий ч ОНЦА-д олгох нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэлд юуг хамааруулах, хэрэглэх нөхцөл, журмыг зохицуулаагүй. Тусгай хэрэгслийг хүний эрх, эрх чөлөөнд халдаж хэрэглэдэг тул үүнийг хэрэглэх алба хаагч тусгайлан бэлтгэгдсэн байхын зэрэгцээ хүний эрхийн боловсролтой байх шаардлагатай. Мөн хэрэглэх нөхцөл, журмыг нарийвчлан зохицуулсан байх учиртай. ОНЦА-ны дүрмийн 4.1-т заасан сургалтын хөтөлбөрт “нэг бүрийн тусгай хэрэгсэл” хэрхэн хэрэглэх талаар тусгаагүй. Хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварын 4.1-т нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг гэсэн хэсэгт Засаг даргад үүрэг болгосон, үүний зэрэгцээ Цагдаагийн албаны тухай хуулиар тухайн шатны Засаг дарга нэг бүрийн тусгай хэрэгслийн зардлыг хариуцахаар байтал Хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварт цагдаагийн байгууллага хариуцахаар заасан зэрэг зөрчилтэй зохицуулалт үйлчилж байна.
- ОНЦА нь дүрмийн 2.2.8-д заасан “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад туслалцаа үзүүлж, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн ангилал нь тохирохгүй, эсхүл жолоодох эрхийн үнэмлэхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулахгүй байх” чиг үүргийг хэрэгжүүлэх бодит боломжтой эсэхийг нягтлах шаардлагатай.
- Цагдаагийн албаны тухай хуулийн 24.11.1-д зааснаар ОНЦА нь хуулиар харьяалуулсан зөрчилд торгууль ногдуулахаар заасан ч хууль хэрэгжээд 2 жил болоход мониторингид хамрагдсан газруудад ОНЦА-д торгуулийн хуудас олгоогүй байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 568-р тушаалаар шинэчлэн батлагдсан Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрмийн 5.3-т энэ чиг үүргийг хэрэгжүүлэх заалтыг нэмж тусгажээ.
- ОНЦА-ны урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоох нь түгээмэл байгаа бөгөөд урамшууллаас шалтгаалан ОНЦА тогтвор суурьшилгүй



болж ихээхэн өөрчлөлт хөдөлгөөн гарч байна. Улаанбаатар хот, Орхон аймагт ажлын үр дүнг харгалзан зарим ОНЦА-д нэмэгдэл урамшуулал олгожээ.

- Урамшууллыг сумын төсвөөс гаргаж байгаа тохиолдолд ОНЦА нь сумын ЗДТГ-ын ажилд туслалцаа үзүүлэх ёстой гэх буруу хандлага гарч байна.
- ОНЦА-ны хувцасны тухайд жилийн хавар, намрын цагт өмсөх гадуур хувцас олгодоггүйн зэрэгцээ материалын чанар муу, байнга гадаа ажилладаг, халуун наранд байх онцлогийг харгалзаагүй гэсэн шүүмжлэл гарч байна.
- ОНЦА-ны хөдөлмөр хамгааллын хувцас цагдаагийн алба хаагчийн хувцастай тун төстэй хийгдсэн нь ОНЦА-ны тухай буруу ойлголт төрүүлж байна. Тухайлбал “мөрөөдлийн цагдаа”, “хэт цэрэгжсэн” зэрэг шүүмжийг дагуулж байлаа.
- Цаг үеийн онцлогоос шалтгаалан ОНЦА нь нийтээр амрах баярын өдөр, амралтын өдрүүд, илүү цагаар ажиллах нь түгээмэл байгаа ч урамшууллыг тооцож олгохгүй байна.
- Цаашид ОНЦА-ыг өөрийнх нь оршин суудаг нутаг дэвсгэрт томилж ажиллуулахад анхаарах нь зүйтэй.

МОНИТОРИНГИЙН ЯВЦАД ЦУГЛУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ

Хүснэгт 1. Урамшуулал олгож буй байдал

№	Аймгийн нэр	Иргэний зөвлөл	ОНЦА	Санхүүжилтийн эх үүсвэр
1	Баян-Өлгий	Зөвхөн нарийн бичгийн даргад 200000 төгрөг өгч байсан ч 2015 оны 10 сараас энэ урамшуулал зогссон.	192000	8 сум ОНЦА ажиллуулахаар томилсон ч Сагсай, Цэнгэл сумын ОНЦА л урамшуулал авч байгаа бөгөөд сумын төсвийн давсан орлогоос санхүүжүүлсэн. ИЗ-ийн төсвийг ГХУСА33-ийн төсвөөс олгосон.
2	Булган	ХХОАТ, НДШ-ийг 200000 төгрөгөөс хасаж, гарт олгоно.	250.000-350.000	ИЗ-ийн гишүүдийн урамшууллыг ГХУСА33-өөс, ОНЦА-ыг сумын ИТХ-ын давсан орлогоос
3	Дархан-Уул	2014 оны сүүлийн 2 сар, 2015 онд 192000 төгрөг олгосон.	192000	ОНЦА-ы урамшуулалд ГХУСА33-ийн төсвийн 80%-ийг зарцуулдаг тул, өөр зорилгод зарцуулах төсөвгүй болдог. ИЗ-ийн урамшууллыг ЗДТГ өгдөг.
4	Завхан	ИЗ-ийн гишүүнд 2014 онд 30000 төгрөгийн урамшуулал өгч байгаад 2015 оноос 50000 төгрөгөөр тогтоосон.	192000	ОНЦА-ы урамшууллыг 2015 оны 5 сараас олгохыг зогсоож, чөлөөлсөн. ИЗ-ийн урамшууллыг аймгийн ЗД-ын нөөц сангаас, ОНЦА-ны урамшууллыг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр сумдын засаг дарга нартай тохирсон ч хууль зөрчсөн тул хэрэгжүүлээгүй.
5	Сэлэнгэ	ИЗ дарга 210000, нарийн бичгийн дарга 190000, гишүүд 180000	300000	Иргэний зөвлөл болон ОНЦА-ы урамшууллыг ГХУСА33-ийн төсвөөс олгосон.
6	Орхон	2015 оны 5-р сараас 200000	350000	ОНЦА-ы сургалтын зардал 1900000 төгрөгийг ИТХ-ын дэргэдэх ГХУСА33-ийн зардлаас, бусад зардал болох урамшуулал, хувцас хэрэглэлийн зардлыг орон нутгийн төсвөөс гаргасан. ИЗ-ийн төсөв ИТХ-аас өгч байгаа. Үйл ажиллагааны зардлыг ИТХ-ын зардалд тусгасан. Сангийн яам мөнгөө татсан тул үйл ажиллагааны зардал ИЗ-д олгогдоогүй.
7	Увс	2014 онд урамшуулал олгоогүй. 2015 оны 2,3-р улиралд ирцийг харгалзан сард 15000 олгосон.	Төсөв байхгүй.	ИЗ-ийн төсвийг ГХУСА33-ийн төсвөөс олгосон.
8	Улаанбаатар	375000	439239	ИЗ, ОНЦА-ны урамшууллыг Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн төсвөөс санхүүжүүлдэг.



9	Ховд	Урамшуулалгүй	100000	ИТХ-ын төсвөөс ОНЦА-ы урамшууллыг өгч байна.
10	Хөвсгөл	Урамшуулалгүй	192000	Их-Уул, Тосонцэнгэл сум Засаг даргын тамгын газрын давсан орлогоос алдаг оног олгодог. 2016 онд урамшуулал олгох асуудал хүндрэлтэй байна.

Хүснэгт 2. Иргэний зөвлөлийн үйл ажиллагаа

№	Аймгийн нэр	Нэр дэвшигчдийн тоо	Гишүүдийн тоо	Тайлбар
1	Баян-Өлгий	10	7	Радиоогоор зарлаж, ЗДТГ-ын цахим хуудас болон олон нийтийн зарын самбарт зар гаргасан. Сонгон шалгаруулалтыг зөвхөн цахим хуудсаар хийсэн. ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. Өрөө гаргаж өгсөн ч цахилгаангүй.
2	Булган	12	5	Сумдад хүргүүлж, ирсэн саналыг үндэслэн ИЗ-ийн гишүүдийг томилсон. Иргэний танхимд ажилладаг. Гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон.
3	Дархан-Уул	16	5	Лха, DBS ТВ, сум, багаар дамжуулан зарлаж, санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. Ажлын өрөөгүй.
4	Завхан	16	5	Цахимаар, ИТХ-ын ил тод байдлын самбар, орон нутгийн ТВ-ээр зар тараасан. Гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон. Ажлын өрөөгүй, иргэний танхимд хуралддаг.
5	Сэлэнгэ	14	5	Мэдээллийн самбар, бусад хэлбэрээр мэдээлэл тарааж, бүх сумын багийн ИНХ, ИТХ нэр дэвшигч бүрээр хэлэлцүүлж, санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. Иргэний зөвлөл ИТХ-ын ажлын албаны дэргэд тусдаа өрөөтэй. ИЗ-ийн гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон. Иргэний зөвлөл нь үйл ажиллагааны төсөв байхгүй.
6	Орхон	18	5	Эрдэнэт, Номин, Лха, ТВ10 телевиз, FM 107.1 радио, www.erdenet.mn , www.IH-orhon.mn , www.lavlah.mn сайтаар зарлаж, Баян-Өндөр, Жаргалант сумдын ИТХ, багуудын ИНХ-д албан тоотоор хүргүүлж санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. Гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон. Ажлын өрөө гаргасан ч засвар хийх шаардлагатай.
7	Увс	9	7	САМС, МВС ТВ, ИТХ-ын цахим хуудсанд зар тавьж, сумдын ИТХ-д албан тоот хүргүүлж, санал авах замаар ИЗ-ийн гишүүдийг томилсон. ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. ИЗ нь тогтмол ажлын өрөө байхгүй, хуралдах үед нь ЗДТГ-ын хурлын танхимаас гаргаж өгдөг.
8	Улаанбаатар	14	7	UBS, C1 TV, Өдрийн сонин, монголын нэг өдөр сонин, www.ulaanbaatar.mn , www.citycouncil.mn сайтаар олон нийтэд зар хүргэж, цахимаар санал авч ИЗ-ийн гишүүдийг томилсон. Нийслэлийн цагдаагийн газарт ажлын өрөө гаргаж өгсөн. ИЗ-ийн гишүүдийг хуулийн дагуу ялгаатай хугацаагаар томилсон.
9	Ховд	9	5	ИЗ-ийн гишүүдийг ялгаатай хугацаагаар томилоогүй. Ажлын өрөөгүй.
10	Хөвсгөл	6	5	Цагдаагийн газарт ажлын өрөөтэй.



Хүснэгт 3. Олон нийтийн цагдаагийн ажилтан

№	Аймгийн нэр	ИТХ-аас тогтоосон ОНЦА-ны тоо	Ажиллаж буй ОНЦА	Тайлбар
1	Баян-Өлгий	16	4	Сумд өөрсдөө шийд гэсэн чиглэл өгсөн бөгөөд зөвхөн Сагсай сум хувцас хэрэгслээр хангасан.
2	Булган	21	18	Илүү цагийн хөлс олгох төсөвгүй. Хөдөлмөр хамгааллын хувцсаар хангагдсан. Тусгай хэрэгслээр хангагдаагүй.
3	Дархан-Уул	21	11	ГХУСАЗЗ-ийн зардлыг бүхэлд нь авч байгаа тул цаашид санхүүжилтийг өөрөөр шийдэх хэрэгтэй. Хөдөлмөр хамгааллын хувцсаар хангагдсан.
4	Завхан	31	16	2015 оны төсөвт хасалт хийснээс 2015 оны 5 сараас бүгдийг чөлөөлсөн. 11 сумын 16 ОНЦА-ы 4 сар ажилласан урамшууллыг ч өгч чадаагүй. Хөдөлмөр аюулгүй байдлын хувцас, тусгай хэрэгсэл олгоогүй.
5	Сэлэнгэ	16	16	2014 онд 34720000 төгрөгөөр борооны цувнаас бусад хувцас хэрэгслийг олгожээ. 6 суманд 16 ОНЦА ажиллаж байна. 32 хүний хүсэлтийг авч, 19 хүн сургалтад сууснаас 19 тэнцсэн. Урамшууллаас шалтгаалж 8 хүн ажлаас чөлөөлөгдсөн. Илүү цагийн урамшуулал байхгүй.
6	Орхон	25	25	Орон нутгийн төсвөөс 164218000 төгрөгийн хувцас хэрэгсэл, урамшууллын зардлыг гаргасан. Сургалтын 1900000 төгрөгийг ГХУСАЗЗ-ийн төсвөөс гаргасан. Ажлын үр дүнг харгалзан хоёр ОНЦА-ны урамшууллыг 10% нэмсэн. Тусгай хэрэгсэл цагдаагийн нөөцөд байгаа ч хэрэглэх журмыг ХЗЯ батлаагүй тул өгөөгүй. Торгуулийн хуудсыг ЦЕГ-ын мэдээллийн санд ОНЦА сан нээгдээгүй тул олгоогүй.
7	Увс	37	-	Төсөв байхгүй тул 18 хүнийг сургасан ч ажиллуулаагүй.
8	Улаанбаатар	300	224	
9	Ховд	18	17	Хөдөлмөр хамгааллын хувцас, тусгай хэрэгслээр хангагдаагүй. Цагдаад өрөөтэй.
10	Хөвсгөл	36	13	ОНЦА 13 суманд ажиллаж байгаа бөгөөд дүрэмт хувцас, тусгай хэрэгслээр хангагдаагүй. Сумаас ОНЦА урамшуулал өгдөг тул өөрсдийн ажилд дайчлах гэдэг. 2014 оны сүүлийн хагасаас үйл ажиллагааны төсөвгүй тул хасагдсан.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдал амьдралд хэр бодитой хэрэгжиж байгаад төрийн бус байгууллага (ТББ)-ууд мониторинг хийдэг билээ. Мониторингийн гол үр дүнг энэхүү МОНИТОР цувралаар олон нийтэд хүргэхийн сацуу төрийн үйлчилгээг цаашид боловсронгуй болгох чиглэлээр мониторинг хийсэн байгууллагууд нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг юм.